

АЗИ НОМХОН ДАЛАЙН БҮС НУТГИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ИНТЕГРАЦИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ЦААШДЫН ЧИГ ХАНДЛАГА

Ц.Баатар¹

APEC was established in 1989 in Canberra, Australia with 12 members. Its origins lay with the desire of the founding members to promote economic growth, foster and strengthen trade, and improve living standards. APEC started with a modest program of sectoral and trade negotiations. From the beginning, APEC has seen itself not as a grouping of countries, but of economies, the term emphasizing that the organization discusses economics, not politics. It was also established as a loose consultative forum, with no organization structure or a large bureaucracy supporting it. Indeed, even today, the APEC Secretariat, which is located in Singapore, includes only 23 diplomats seconded from APEC member economies in addition to 20 locally hired staff.

It was in 1993 that an annual meeting of APEC Leaders became a regular feature of APEC. Only one year after this first meeting, which was held in the U.S., APEC Leaders took another historic step at their meeting in Bogor, Indonesia. At this meeting, the Leaders declared a bold goal of creating the world's largest area of free trade and investment by 2020. Within APEC, this challenge became known as the "Bogor Goals." Under the plan, developed economies would achieve free trade by the year 2010 and developing economies would follow in 2020.

APEC's 21 members today are: Australia; Brunei Darussalam; Canada; Chile; the People's Republic of China; Hong Kong, China; Indonesia; Japan; South Korea; Malaysia; Mexico; New Zealand; Papua New Guinea; Peru; the Philippines; Russia; Singapore; Chinese Taipei; Thailand; the United States; and Viet Nam.

This article delivers the authors assessment of the current status of the Asia-Pacific economic integration, the free trade negotiations taking place in the region and the trend going forward.

¹ ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэнгийн ЭШТА, доктор (Sc.D), профессор.

Түүхэн тойм

Одоогоос 27 жилийн өмнө бүс нутгийн орнуудын эдийн засаг улам бүр харилцан хамааралтай болж буй бодит нөхцөл байдлаас үүдэн 1989 оны 11 дүгээр сарын 6-7-ны өдрүүдэд Австралийн нийслэл Канберрад энэ бүс нутгийн Австрали, Бруней Даруссалам, Канад, Индонези, Япон, Малайз, Шинэ Зеланд, Филиппин, Сингапур, Өмнөд Солонгос, Тайланд, АНУ гэсэн 12 орны гадаад хэргийн болон гадаад худалдаа, эдийн засгийн сайд нар “Ази-Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагаа /Asia-Pacific Economic Cooperation буюу АПЕК/” гэсэн форумыг зохион байгуулснаар АПЕК-ийн эхлэл тавигдсан. Улмаар 1991 онд Хятад, Хятадын Тайван, Хонконг, Мексик, 1993 онд Папуа Шинэ Гвиней, 1994 онд Чили, 1997 онд Перу, Вьетнам, ОХУ нэгдэн орсноор өнөө 21 гишүүн эдийн засгаас бүрдэх болжээ. АПЕК-нь «байгууллага» гэхээсээ илүү тодорхой зорилт дээр нэгдсэн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны «үйл явц» болж, бүс нутгийн орнуудын өсөн нэмэгдэж байгаа хамтын ажиллагаа, эдийн засгийн түргэн өсөлт, худалдаа, хөрөнгө оруулалтыг либералчлалын аргаар баталгаажуулах зорилготой юм. АПЕК-ийн либералчлалын үйл явц заавал биелүүлэх шинжтэй дүрэм жураманд захирагдах бус харилцан зөвшөөрсөн зарчмууд дээр тулгуурласан сайн дурын үндсэн дээр үйл ажиллагаагаа явуулдаг. Үүгээрээ тодорхой тогтсон тоглоомын дүрэм журам, дэг ёс, үүрэг хариуцлага хүлээдэг ДХБ-аас зарчмын ялгаатай. АПЕК-ийн форум аажмаар энэ бүс нутагт чөлөөт худалдаа, хөрөнгө оруулалт, эдийн засгийн хамтын ажиллагаанд тус дэм үзүүлэх байгууллага болон хувирч, түүний статус нь сайд нарын түвшинээс ахиж гишүүн эдийн засгийн удирдагчдын дээд түвшний уулзалт болон өргөжжээ. Гишүүн эдийн засгийн удирдагчдын жил бүрийн уулзалтыг орон тус бүр ээлжээр хүлээн авч зохион байгуулдаг журамтай. Өнөөдөр АПЕК-ийн орнууд эдийн засгаа амжилттай хөгжүүлж, энэ бүс нутаг нь эдийн засгийн өсөлтөөр бусад бүс нутгийг давамгайлж, улмаар дэлхийн эдийн засгийн хөгжлийн нэг төв болж байна.

Өнөөгийн байдал

Өнөөгийн байдлаар энэ бүс нутагт 3 тэрбум орчим хүн аж төрж, дэлхийн ДНБ-ий 60, дэлхийн худалдааны 50 орчим хувь ногдож байна².

АХБ-ны Азийн бүс нутгийн интеграцийн судалгааны төвөөс Ази дахь хоёр болон олон талт чөлөөт худалдааны хэлэлцээр түүний хэрэгжилтийн талаар хийсэн судалгаанаас үзэхэд 2006-2016 оны 2 дугаар сар хүртлэх 10 жилийн хугацаанд Ази тивийн хэмжээнд хоёр болон олон талт чөлөөт худалдааны 220 хэлэлцээр байгуулжээ³. Түүнээс өнөөгийн байдлаар 140 гэрээ хүчин төгөлдөр үйлчилж, үр ашгаа өгч байгаа бол 67 гэрээ хэрэгжилтийн шатанд, бусад гэрээ соёрхон батлах түвшинд байгаа аж. Ийнхүү Азиуд Европ шиг нэгдсэн холбоо байгуулах нөхцөл бүрдээгүй ч улам бүр харилцан ашигтай, хамтран ажиллах хүсэл эрмэлзэлтэй болж, бүс нутгийн хамтын ажиллагааны олон байгууллагатай болжээ. Эдгээрийн дотроос АПЕК хамгийн өгөөжтэй ажиллаж, мэдээллийн технологийн үр шимийг хүртэн, нийтлэг олон асуудлыг хамтран хэлэлцэж, үйл ажиллагаагаа уялдуулан зохицуулж тодорхой амжилтад хүрч ирлээ.

Өнөөдөр АПЕК дэлхийн эдийн засгийн зүтгүүрийн үүрэг гүйцэтгэж өнөөгийн хүндрэлийг даван туулахад нэгэн гол түшиг тулгуур нь болж байна. Энэ аварга том мега бүс нутаг бусад бүс нутгаас ер бусын онцлогтой. Тухайлбал, оролцогч эдийн засаг, оролцож буй хүн ам, эдийн засгийн олон талт байдал, цар хүрээ, хөгжингүй болон хөгжиж буй эдийн засаг, нийгэм, улс төр, засаглалын тогтолцоо, хамтын ажиллагааны маш олон механизм хоорондын ашиг сонирхлын зөрчил, хурц ялгаа гэх мэтийг энд тоочоод барамгүй. Гэсэн хэдий ч гишүүн эдийн засгууд улам бүр даяаршиж байгаа өнөөгийн ертөнцөд зах зээлээ тэлэх, ялангуяа ойрын хөршүүдтэйгээ худалдаа, хөрөнгө оруулалтаа өргөжүүлэх туйлын сонирхол тэднийг нэгтгэж, худалдаа, хөрөнгө оруулалтын хувьд харилцан хөнгөлөлт үзүүлж ирсний үр дүнд тогтвортой өсөлтөө хадгалсан хэвээр явна.

АПЕК-ыг анх үүсгэн байгуулж эхлэхээс өмнө Ази, Номхон далайн бүс нутагт хамтын ажиллагааны 3 механизм, чөлөөт худалдааны

2 http://www.statistics.apec.org/index.php/key_indicator/

3 <http://www.adb.org/>

гуравхан гэрээ үйлчилж байсан бол өнөөгийн байдлаар энэ бүс нутагт 25 хамтын ажиллагааны механизм, 56 чөлөөт худалдааны хэлэлцээр хүчин төгөлдөр үйлчилж байна⁴. АПЕК-ийн гишүүн эдийн засгууд хооронд худалдааны либералчлал, худалдааг хөнгөвчлөх чиглэлд ахиц өөрчлөлт гарсаар байна. Үүнийг 2015 онд хэвлэлээс гарсан АПЕК-ийн худалдаа, хөрөнгө оруулалтын 1992-2014 оныг хамарсан статистик үзүүлэлтүүдээс харж болох байна⁵. Тухайлбал, гишүүн эдийн засгуудын ДНБ (худалдан авах чадвараар) 1992 онд 16.4 триллион байсан бол 2014 онд 59.1 триллион болж 3 дахин өсч, хүн ам тутамд ногдох ДНБ 1992 онд 7439 ам.доллар байсан бол 2014 онд 20811 ам.долларт хүрсэн бол АПЕК-ийн гишүүн бус улсуудынх мөн хугацаанд 4855-15153 ам.доллар болсон байна. Мөн хугацаанд гишүүн эдийн засгуудын дундаж тарифын түвшин 16.9-аас 5.8 хувь болон буурч, бараа үйлчилгээний худалдааны экспорт, импорт аль аль нь ижил хэмжээнд буюу 2-11.2 триллион ам.долларт хүрч бараг тав дахин нэмэгдэж, гишүүн эдийн засгийн нийт худалдааны 68.2 хувийг эзлэх болж, гадаадын шууд хөрөнгө оруулалт 2014 онд 12.4 ам.долларт хүрсэн нь дэлхийн хэмжээнд оруулсан гадаадын шууд хөрөнгө оруулалтын 50.3 хувийг эзэлж байгаа бол гишүүн эдийн засгуудаас бусад орнуудад оруулсан гадаадын шууд хөрөнгө оруулалт 12.9 триллион ам.доллар болсныг дэлхийн хэмжээнд авч үзвэл 52.4 хувийг эзэлж буй аж. Түүнчлэн худалдааг хөнгөвчлөх хөтөлбөр хэрэгжүүлснээр гишүүн орнуудын хоорондын ажил гүйлгээний зардлыг 5 хувиар бууруулж чадсан байна. Ийнхүү гишүүн эдийн засгууд хамтын ажиллагааны үр дүнг хүртсээр байгааг дээрх статистик гэрчилнэ

АПЕК-ийн дэвшүүлсэн зорилт, хэрэгжилт

Одоогоос хорин хоёр жилийн өмнө буюу 1994 онд Индонезийн Богорт болсон АПЕК-ийн удирдагчидын дээд хэмжээний уулзалтаар “Ази Номхон далайн бүс нутагт худалдаа, хөрөнгө оруулалтын чөлөөт тогтолцоо”-г бий болгох хугацаат зорилт тавьсан. Энэ хүрээнд гишүүн үйлдвэржсэн орнууд 2010 он, хөгжиж байгаа орнууд 2020 он гэхэд чөлөөт болон эзэлттэй худалдаа, хөрөнгө оруулалтын орчныг бий

4 www.apec.org/Groups/Other.../FTA_RTAs.asp

5 <http://www.draft.gov.au/about-us/publications/Documents/apec-2015.pdf/>

болгохоор тохиролцсон⁶. Богорт дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх үүднээс 1996 онд Малайзын Манила хотноо болсон эдийн засгийн тэргүүнүүдийн дээд хэмжээний уулзалтаар АПЕК-ийн Манилагийн үйл ажиллагааны төлөвлөгөө /МҮАТ/-г баталжээ. Гишүүн орнууд нь зах зээлээ нээлттэй болгох, эдийн засгийн өсөлтөө дэмжихийн тулд хамтдаа буюу дангаараа үйл ажиллагааны тодорхой төлөвлөгөө гарган түүнийгээ 1997 оноос хэрэгжүүлж эхэлсэн. Энэ хүрээнд ямар арга хэмжээ авсан, эхлүүлсэн ажлын явц байдлыг Удирдах ахлах албан тушаалтнуудын уулзалт (Senior officials Meeting) болон Сайд нарын, эцэст нь Төрийн тэргүүнүүдийн дээд хэмжээний уулзалтуудаар хэлэлцүүлэн баталгаажуулж иржээ. Орон бүрийн энэ чиглэлийн үйл ажиллагааны төлөвлөгөөнөөс үзэхэд дийлэнх орнууд жижиг, дунд үйлдвэрүүдээ олон улсын худалдаа, үйлдвэрийн гинжин сүлжээнд оруулах, боловсролын талд их, дээд сургуулиуд хамтран ажиллах, хүний нөөцийг улам бүр чадвахижуулах улмаар бүс нутагт судалгааны байгууллагуудын урсгал хөдөлгөөнийг чөлөөтэй болгож, эрдэмтэн судлаачдын хамтарсан баг ажиллуулах, хүнсний стандарт болон аюулгүй байдал, дэд бүтцийн чанарыг баталгаажуулах, дэд бүтцийн хоорондын холбогдох чадварыг дээшлүүлэх, гишүүн орнууд нэг стандартад нэгдэх, эмэгтэйчүүдийн бизнес эрхлэлтийг дэмжих, интернэтийн эдийн засаг, худалдааг дэмжин хөгжүүлэх, цахим сургалтын төвүүдийг нээн ажиллуулах зэрэг олон арван шинэ санал, санаачилга дэвшүүлэн түүнийгээ бодит ажил хэрэг болгон амжилттай хэрэгжүүлж ирсэн байна.

Ийнхүү өнгөрсөн 22 жилийн хугацаанд АПЕК-ийн эдийн засгууд Богорын зорилтыг хэрэгжүүлэхэд ихээхэн хүчин зүтгэл гаргаж, бүс нутгийн хамтын ажиллагааг тууштай ургашлуулахад ихээхэн хувь нэмэр оруулж, түүний жин нөлөөг бэхжүүлж чадсан байна. Гэсэн хэдий ч, ахиц дэвшлийн зэрэгцээ, шинэ асуудал, сорилт бэрхшээлүүд ч гарч байна. Энэ бүс нутгийн орон тус бүр дээр өгүүлснээр хоёр болон олон талт худалдааны зохицуулалтын төрөл бүрийн давхардсан гэрээ, хэлэлцээртэй тул АПЕК-ийн гишүүн эдийн засаг нэгдэх бус хэд хэдэн хэсэг бүлэглэл болон дотроо задарч ч болзошгүй эрсдэлтэй нөхцөл байдал үүсээд байна. Үүнд олон хүчин зүйл нөлөөлж байгаа

⁶ <http://www.apec.org.com/bogor>

хэдий ч хамгийн гол нь энэ бүс нутгийн голлон тоглогчид хоорондын өрсөлдөөн, тэргүүлэх байр суурийг хэн нь гартаа авах вэ гэдэгт л байгаа юм.

Ази Номхон далайн чөлөөт худалдааны хэлэлцээр (FTAAP)

Богорын зорилтын хүрээнд Чөлөөт худалдааны бүс байгуулахтай холбогдсон бэлтгэл ажил үе шат дамжин хэрэгжиж дараагийн шатанд орж 2006 оны АПЕК-ийн дээд хэмжээний уулзалтаар Ази Номхон далайн чөлөөт худалдааны бүс байгуулах бэлтгэл ажлыг эхлүүлэхээр шийдвэрлэсний дагуу түүний Техник эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ) боловсруулах судалгаа шинжилгээний ажлыг гишүүн орон тус бүрийн АПЕК-ийн судалгааны төвүүд хийж эхэлсэн. Энэхүү судалгаанд АПЕК-ийн 21 гишүүн бүгд хамрагдсан. Түүнээс хойш судалгааны үр дүнг шат шатны ажлын хороод жил бүр хэлэлцэж, жил бүрийн дээд хэмжээний уулзалтуудад тайлагнаж иржээ. АПЕК-ийн гишүүн эдийн засгийн тэргүүн нарын 2010 оны дээд хэмжээний уулзалтаар АПЕК-ийн эдийн засгийн удирдагчид FTAAP төслийг хэлэлцэж шинэ үед хандсан, урт хугацааны зорилгод чиглэсэн стратеги болохыг сайшаан хүлээн зөвшөөрч уг төслийг хамтарсан тунхаглалд хавсарган хэвлүүлсэн байна⁷. Тунхаглалд FTAAP-ыг цогцоор авч үзсэн, чанарын өндөр түвшинд дараагийн үеийн худалдаа, хөрөнгө оруулалтын асуудлыг зохицуулах механизм гэж тодорхойлсон байна. 2013 оны АПЕК-ийн Эдийн засгийн удирдагчдын дээд хэмжээний уулзалтаар FTAAP-т урьтал болгон гишүүн эдийн засгуудын хоёр талын Чөлөөт худалдааны хэлэлцээрүүдийг нэгтгэх, хоорондын зохицуулалтыг хэрхэн хийх талаарх урт удаан хугацааны судалгааны ажлыг орон гишүүн эдийн засаг бүрийн АПЕК судлалын төвүүд үргэлжлүүлэхээр тогтсон⁸.

Номхон далай дамнасан түншлэлийн хэлэлцээр (Trans Pacific Pathnership-TPP)

Бүс нутгийн чөлөөт худалдааны хэлэлцээрийн хүрээнд хэлэлцэж эхэлсэн өөр нэг хэлэлцээр бол Номхон далайн дөрвөл болох Бруней,

7 <http://www.apec.org.com/2010/>.

8 <http://www.apec.org.com/2013/>

Чили, Сингапур, Шинэ Зеландын хооронд 2005 онд байгуулсан “Номхон далайн орнуудын стратегийн хамтын ажиллагааны гэрээ” юм. Эл гэрээ бүс нутгийн гишүүн эдийн засгуудын хооронд байгуулсан урд өмнөх гэрээ, хэлэлцээрүүдээс илүү ашигтай байсан тул түүнд нэгдэх сонирхолтой орнууд нэмэгдэж, хэлэлцээр байгуулах яриа хэлэлцээг өрнүүлэх болсон. Тухайлбал, 2010 онд дээрх дөрөв дээр АНУ, Австрали, Сингапур, Вьетнам, Малайз улсууд нэгдэх эрмэлзлээ илэрхийж яриа хэлэлцээг эхлүүлсэн бол 2012 онд Мексик, Канад, 2013 онд Япон нэгдэн оржээ. Анхны гэрээ нь дээрх өргөтгөсөн хэлэлцээрийн эх тулгуур баримт бичиг болгон авч, нэрийг нь Номхон далай дамнасан түншлэл (Trans Pacific Pathnership-TPP) хэмээн өөрчилсөн байна. Хэлэлцээр нэгдсэн орнуудын хүчин чармайлт, АНУ-ын давамгайлсан шахалтын дор 2015 оны аравдугаар сарын 5-нд нэгдсэн тохиролцоонд хүрч, улмаар 2016 оны 2 дугаар сарын 03-нд Шинэ Зеландын Окланд хотноо гишүүн 12 улсын төлөөлөгчид гарын үсэг зурж баталгаажуулсан⁹. Энэ хэлэлцээрийг эдгээр 12 гишүүн орны парламент соёрхон баталсны дараа 2018 оноос хэрэгжих шатандаа орох байлаа. Гэтэл энэ хэлэлцээрийн хувь заяа бүрэгдүү, хэрэгжих магадлал багасч байх шиг байна. Учир нь Дональд Трамп уг гэрээг “хамгийн муу гэрээ” гэж нэрлэсэн бөгөөд Америкийн бүх ажлын байрыг эдгээр улс орнуудын хямд ажиллах хүчинд илгээсэн гэж үздэг. ТТР-г АНУ-ын Конгрессээр батлуулах ёстой. Өөрөөр хэлбэл Трампын хамтрагчид буюу Бүгд Найрамдах намынхан гарын үсэг зурснаар баталгаажих байлаа. АПЕК-ийн гишүүн эдийн засгийн удирдагчид Лимагийн дээд хэмжээний уулзалтаар “Дональд Трампыг ерөнхийлөгчийн сонгуульд ялалт байгуулсныг үл харгалзан чөлөөт худалдааны гэрээг цааш үргэлжлүүлэх болно” гэж мэдэгдсэний дараахан буюу энэ сарын 21-ний өдөр АНУ-ын ерөнхийлөгчөөр сонгогдсон Дональд Трамп ирэх нэгдүгээр сард үүрэгт ажлаа хүлээж авсан эхний өдрөө “TPP-Trans-Pacific Partnership” худалдааны гэрээг цуцлахаа олон нийтэд мэдэгдлээ. Ингээд Америкгүй TPP цааш явах эсэх асуудал тулгарч байна.

Бүс нутгийн эдийн засгийн иж бүрэн түншлэл (Regional Comprehensive Economic Partnership-RCEP)

⁹ <https://www.tpp.mfat.govt.nz/>

АНУ-ын санаачилсан ТРР-г байгуулах хэлэлцээнд Орос, Хятад хоёрыг уриагүй нь АПЕК-ийн гишүүдийн хүрээнд үл ойлголцол төрүүлж эхэлсэн. Өөрсдийг нь урилгүйгээр, түншлэл байгуулах нөхцлөө өөрсдийнх нь оролцоогүйгээр шийдсэн учраас Орос, Хятад хоёр дээрх хэлэлцээрт нэгдэх дургүй байгаа нь ойлгомжтой. Зарим шинжээчид уг түншлэлийг “Хятадын эсрэг худалдааны гэрээ”, “Бүс нутагт Хятадын өсөн нэмэгдэж буй эдийн засгийн нөлөөг тогтоон барихад чиглэсэн арга хэмжээ” гэх мэтээр янз бүрээр дүгнэж ирсэн¹⁰. Тэртэй тэргүй дэлхийн эдийн засаг сайнгүй байгаа энэ цаг үед эдийн засгийн бүхэл бүтэн интеграцийг дотор нь ингэж хэсэглэн хуваах нь ойлгомжгүй үйлдэл гэж үзэх шинжээчид олон бий. АНУ-ын санаачилсан “түншлэл”-ийг сөргүүлэн Хятад улс Бүс нутгийн эдийн засгийн иж бүрэн түншлэл (Regional Comprehensive Economic Partnership-RCEP) хэмээх хамтын ажиллагааны шинэ хэлбэрийг санал болгосон¹¹. Эл түншлэлд Хятад болон АСЕАН-ы гишүүн 10 орноос гадна Япон, Өмнөд Солонгос, Энэтхэг, Австрали, Шинэ Зеланд нэгдэх сонирхолоо илэрхийлж байсан бол Лимагийн дээд хэмжээний уулзалтаар Хятадтай худалдааны өргөн харилцаатай Перу, Чили улс нэгдэх сонирхолоо илэрхийлжээ. Энэ түншлэлд АПЕК-ийн гишүүн бус орон ч орж буй. RCEP нь тарифын болон тарифын бус саад тотгорыг бууруулах зорилготой. Түүнчлэн стандартын шаардлага бага, хялбаршуулсан зохицуулалттай байх аж.

ДҮГНЭЛТ

Ази Номхон далайн бүс нутагт өрнөж буй Чөлөөт худалдааны олон хэлэлцээрүүдээс ойрын ирээдүйд хүч авч хэрэгжих магадлалтай нь Хятадын санаачилсан түншлэлийн хэлэлцээр байж болохоор болж ирлээ. Дональд Трампын ялалт, түүний худалдааны эсрэг байр суурь нь АНУ-ын хөгжил султай, хүн амын суурьшил багасч буй муж улсуудын ард иргэдийн сэтгэлийг эргүүлж чадсан. Одоо Трамп амлалтаа биелүүлж, үүрэгт ажлаа хүлээж авсан эхний өдрөө Хэлэлцээрийг цуцлахаа мэдэгдсэнээр ТРР хэлэлцээр үндсэндээ төгсөх шатандаа орлоо. Энэ мөчид Хятад улс Ази, Номхон далайн эдийн засгийн интеграцид давамгайлах байр суурийг АНУ-аас авахаар

10 <https://nationalinterest.org/.../tpp-vs-rcep-america-china-battle-control-pacific-trade-14021>

11 <https://aric.adb.org/fta/regional-comprehensive-economic-partnership>

*Ази номхон далайн бүс нутгийн эдийн засгийн интеграцийн
өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага*

хором алдахгүй хөдөлж, Лимагийн дээд хэмжээний уулзалтан дээр Хятадын дарга Си Жинпин дэлхийн хамгийн хурдтай хөгжиж буй бүс нутагтай эдийн засгийн хамтын ажиллагаагаа өргөжүүлэхийг уриалж, Ази Номхон далайн чөлөөт худалдааны бүс (ФТААР) байгуулах тал дээр санал нэг байгаагаа илэрхийлсэн. Гэхдээ бүс нутгийн судлаач шинжээчид АНУ болон Латин Америк, Зүүн өмнөд Азийг тэр чигт нь хамарсан Ази Номхон далайн чөлөөт худалдааны бүсийн талаар ярих цаг хараахан болоогүй гэж үздэг. Лимагийн уулзалтаар энэхүү чөлөөт худалдааны бүсийг хэрхэн ашигтай, оновчтой арга замаар хэрэгжүүлэх боломж байгааг судалсан Хятадын АПЕК судлалын төвийн судалгааг танилцуулсан. Энэ үеэр 2013 онд Зүүн өмнөд Азийн орнуудын нийгэмлэгийн 10 оронтой Энэтхэг, Хятад, Япон бусад орон нэгдэж RСЕР санаачлагад нэгдэхийг гишүүн эдийн засгуудад санал болголоо. Өнөөдөр Хятад улс энэ санаачлагыг гартаа авч, төслийг удирдаж эхэлжээ. Гэвч RСЕР гаалийн тариф болон худаалдааны татвар багасгахаас хэтрэхгүй хэмээн Вашингтоны болон бусад шинжээчид үзэж байна. Хятадын дэвшүүлж буй бүс нутгийн цогц эдийн засгийн түншлэлд: Төрийн өмчит компаниудын зохицуулалт, хил дамнансан мэдээллийн урсгалыг хэрхэн хянах талаар TPP-д тусгасан шиг амбийцтай дүрэм журмууд огт байхгүй аж. Brookings хүрээлэнгийн шинжээч Жошуа Мелтцер ”Харамсалтай нь Трампын ялалтын улмаас гишүүн орнууд RСЕР-ийн түншлэлийг Азийн худалдааны цорын ганц хэлэлцэх асуудал хэмээн ойлгож эхэллээ” гэсэн байна. Энэ бүхнээс үзэхэд Хятад улс Ази Номхон далайн эдийн засгийн интеграцид голлон тоглогч болж давамгайлах үүрэг гүйцэтгэх хандлагатай байна.